



СОНГИНОХАЙРХАН ТҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 04 сарын 25 өдөр

Дугаар 458

Улаанбаатар хот

Баянхошуу хайрхан тахих
ёслол үйлдэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дүгээр зүйл, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны 10/10 дугаар тогтоолыг үндэслэн Сонгинохайрхан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Тус дүүргийн Тэргүүн лам нарын зөвлөлтэй хамтран 24, 25 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах дүүргийн тусгай хамгаалалттай Баянхошуу хайрханыг 2017 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр тахих ёслолыг үйлдсүгэй.

2. Баянхошуу хайрхан тахих ёслолыг зохион байгуулах Ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч:

Н.Мөнхбаатар

Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны даргын үүрэг гүйцэтгэгч

Гишүүдэд:

М.Баяраа

Засаг даргын Тамгын газрын дарга

О.Бат-Ирээдүй

Хурлын Ажлын албаны Захиргааны хэлтсийн дарга

Б.Мөнхбаяр

Хурлын Ажлын албаны Зохион байгуулалтын хэлтсийн дарга

Ц.Баттөр

Хурлын Ажлын албаны Иргэний оролцооны хэлтсийн дарга

Т.Сүхбаатар

ЗДТГ-ын Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн дарга

Б.Мөнгөншагай

ЗДТГ-ын Хууль зүйн тасгийн дарга

Д.Мөнх-Эрдэнэ

Хурлын Ажлын албаны ажилтан

Ө.Түмэн-Эрдэнэ

Хурлын Ажлын албаны ажилтан

Г.Батжаргал

Хурлын Ажлын албаны ажилтан

С.Монголбаяр

Жонан Дагдан Чойпиллин хийдийн хамба лам

Нарийн бичгийн дарга:

Ц.Мөнгөнзул

Хурлын Ажлын албаны ажилтан

3. Хайрхан тахих арга хэмжээнд дүүргийн сүсэгтэн олныг өргөнөөр оролцуулан өндөр түвшинд зохион байгуулахыг Ажлын хэсгийн ахлагч /Н.Мөнхбаатар/-д үүрэг болгосугай.

4. Хайрханыг тахих ёслол үйлдэх үед сүсэгтэн олны хэв журам сахиулахад цагдаагийн ажилтны нэмэгдэл хүч гарган ажиллуулахыг дүүргийн Цагдаагийн хоёрдугаар хэлтсийн дарга цагдаагийн хурандаа Т.Бакыт, автомашины замын хөдөлгөөнийг зохицуулж аюулгүй байдлыг хангаж ажиллахыг Замын цагдаагийн хэлтсийн дарга цагдаагийн хошууч Н.Ганбат нарт тус тус үүрэг болгосугай.



ДАРГА

Б.МӨНХЦЭЦЭГ